

NipCA ТӨСЛИЙН ЗҮГЭЭС ИВЭЭН ТЭТГЭСЭН "ТӨВ ЕВРАЗИ БА ЯПОНЫ ИРЭЭДҮЙ" ОЛОН НИЙТИЙН ЦУВРАЛ ЛЕКЦ

**ЛЕКЦ 11 "МОНГОЛ ХҮҮХДҮҮДИЙГ ТҮЛЭГДЭХ ОСЛООС
ХАМГААЛАХЫН ТӨЛӨӨ АМЬДРАХ ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ"**

ЦУКУБАГИЙН ИХ СУРГУУЛИЙН АНАГААХ УХААНЫ ДОКТОР ПРОФЕССОР ИЧИКАВА МАСАО

Supported by  **日本 THE NIPPON
財団 FOUNDATION**

2021 оны 4 дүгээр сар

NipCA ТӨСЛИЙН ЗҮГЭЭС ИВЭЭН ТЭТГЭСЭН "ТӨВ ЕВРАЗИ БА ЯПОНЫ ИРЭЭДҮЙ" ОЛОН НИЙТИЙН ЦУВРАЛ ЛЕКЦ

**ЛЕКЦ 11 "МОНГОЛ ХҮҮХДҮҮДИЙГ ТҮЛЭГДЭХ ОСЛООС
ХАМГААЛАХЫН ТӨЛӨӨ АМЬДРАХ ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ"**

ЦУКУБАГИЙН ИХ СУРГУУЛИЙН АНАГААХ УХААНЫ ДОКТОР ПРОФЕССОР ИЧИКАВА МАСАО

“ТӨВ ЕВРАЗИ БА ЯПОНЫ ИРЭЭДҮЙ” ОЛОН НИЙТИЙН ЦУВРАЛ ЛЕКЦИЙН ТОВХИМОЛД ЗОРИУЛСАН УДИРТГАЛ ҮГ

ҮСҮЯМА ТОШИНОБУ

ЦУКУБАГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮМҮҮНЛЭГИЙН УХААНЫ САЛБАРЫН ДОКТОР ПРОФЕССОР, NipCA
ТӨСЛИЙН ХАРИУЦАГЧ, ОЛОН УЛСЫН ХАРИЛЦААНЫ БОЛОВСРОЛЫН ТӨВИЙН УДИРДАГЧ

Цукубагийн их сургууль дахь “Ниппон Сангийн Төв Ази - Японы Хүний Нөөц Хөгжүүлэх Төсөл (NipCA)” нь анх 2019 оны 1-р сард Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн яамнаас “Их сургуулиудыг дэлхийн хэмжээнд хөгжүүлэх төсөл (ОХУ)”-ийн хүрээнд Цукубагийн их сургуульд өрнүүлсэн “Орос хэл хэрэглэгддэг улс орнуудад чиглэсэн аж үйлдвэрт идэвхтэй үүрэг гүйцэтгэх гадаад хэл эзэмших хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр” (2014-2019)-ийн ололт амжилт, ноу-хауг агуулж шинэчлэгдэн батлагдсан. NipCA төсөл нь тухайн улсын нийгмийн хөгжилд идэвхтэй үүрэг гүйцэтгэж чадах хүний нөөцийг бэлтгэх, түүнийг бүрдүүлэх зэрэг олон арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлдэг. Үүний нэг жишээ нь “Төв Еврази ба Японы Ирээдүй” сэдэвт олон нийтийн цуврал лекц юм. Эдгээр цуврал лекцүүдийн зорилго нь SDGs буюу НҮБ-аас тогтоосон тогтвортой хөгжлийн зорилгод хувь нэмэр оруулж чадахуйц санаачилгын талаар илүү дэлгэрэнгүй мэдээллүүдийг хүргэхэд оршино. Тус лекцүүдийг 2019 онд нийт 10 удаа, 2020 оны хавар тохиолдсон шинэ төрлийн корона вирусийн тархалттай холбоотойгоор 2020 онд онлайнар нийт 13 удаа зохион байгуулсан ба нэг удаагийн лекцэд ойролцоогоор 60~80 хүн оролцсон байна. Лекцэд хүрэлцэн ирсэн оролцогчдын хүсэлт болон нийгэмд хувь нэмэр оруулах, мэдээлэл хүргэх зорилгын хүрээнд эдгээр лекцүүдийг товхимол хэлбэрээр хэвлэж гаргахаар болсон юм.

Энэ удаагийн товхимол нь “Төв Еврази ба Японы Ирээдүй” олон нийтийн 11 дэх удаагийн цуврал лекц болох “Монгол хүүхдүүдийг түлэгдэх ослоос хамгаалахын төлөө амьдрах орчныг сайжруулах төсөл”-ийг монгол хэл рүү хөрвүүлсэн болно. Үүнээс гадна 11 дэх удаагийн лекцийг уншсан Цукубагийн их сургуулийн анагаах ухааны доктор профессор Ичикава Масаод гүн талархал илэрхийлэхийг хүсэж байна. Профессор Ичикава лекцийн үеэр 1991 оны 4-р сард буюу 29 жилийн өмнө 19 настай оюутан байхдаа Ниппон сангийн зүгээс ивээн тэтгэж байсан дадлагын хүрээнд Таиландын хойд хэсэгт байрлах Чианг Май ба Чианграй хоёрын хооронд орших Виенпапао хэмээх тосгонд очиж байсан талаар ярьсан. Тэр үед Ичикаваг багтаасан 25 залуусаас бүрдсэн багийг Виенпапао уруу дагуулж явсан хөтөлбөрийн удирдагч бол одоогийн Ниппон сангийн удирдах гишүүн Мори Юүжи юм. Профессор Ичикава тухайн үеийн олж авсан туршлага дээр үндэслэн олон улсын хамтын ажиллагааг сонирхох болсон нь Монгол дахь төслийг хэрэгжүүлэх үндэс болсон. Мөн дээрх туршлага нь хүмүүсийн учрал, хоорондын харилцаа холбоо ирээдүйг бий болгодог гэдгийг харуулсан тод жишээ болж чадсан гэж бодож байна. Тодруулбал удирдах гишүүн Мори профессор Ичикаватай адил өмнө нь Монголд үйл ажиллагаа өрнүүлж байсан түүхтэй буюу 2004 оноос хойш Монгол Улсад ТББ-ийн төлөөлөгчөөр 8 жилийн турш ажиллаж байсан ба Ниппон сангийн дэмжлэгтэйгээр Монголын уламжлалт анагаах ухааныг сурталчлах төсөл хэрэгжүүлж байсан. Энэхүү товхимол нь ирээдүйд олон улсын хамтын ажиллагааны төслүүдэд ашиглагдаж монгол хүүхдүүдэд хувь нэмэр болох нь NipCA төслийн хариуцагч Үсүяма миний гол хүсэл юм.

Эцэст нь хэлэхэд, Цукубагийн их сургуулийн NipCA төсөлд халуун дулаан сэтгэлээр дэмжлэг үзүүлдэг Ниппон сангийн удирдах гишүүн Мори Юүжи, олон улсын үйл ажиллагааны салбарын дарга Арикава Такаши, олон улсын үйл ажиллагааны салбарын менежер Хаффман Жеймс, Фүжий Маюми, мөн Япон - Төв Азийн найрамдлын нийгэмлэг (JACAFА)-ийн ерөнхийлөгч Врбоски Киоко нарт чин сэтгэлээсээ талархал илэрхийлмээр байна.

Ямамото Юкико (Цукубагийн их сургуулийн дэд профессор):

Өнөөдөр Цукубагийн их сургуульд 11 дэх удаагаа зохион байгуулагдаж буй “Төв Еврази ба Японы Ирээдүй” олон нийтийн цуврал лекцэд хүрэлцэн ирсэнд маш их баярлалаа. Одооноос Цукубагийн их сургуулийн “Төв Еврази ба Японы Ирээдүй” 11 дэх удаагийн олон нийтийн цуврал лекц эхэлж байна. Өнөөдөр энд хүрэлцэн ирж бидэнтэй хамт байгаа та бүхэнд дахин талархал илэрхийлэхийг хүсэж байна.

Намайг Ямамото Юкико гэдэг. Би Цукубагийн их сургуулийн Хүмүүнлэг, Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль “Ниппон Сангийн Төв Ази - Японы Хүний Нөөц Хөгжүүлэх Төсөл”-ийн ажилтнаар ажилладаг. Танилцсандаа таатай байна.

Энд хүрэлцэн ирсэн та бүхнээс дараах зүйлсийг хүсэж байна. Лекцийн үеэр микрофон болон камераа унтрааж ажиллаарай. Лекц дууссаны дараа асуулт хариултын цаг гарах тул лекцтэй холбоотой асуулт болон санал сэтгэгдэл байвал лекц дуустал түр хүлээгээрэй. Үүнээс гадна, өнөөдрийн лекцийг дараа нь онлайнгаар үзэж болох ба лекцийн бичлэг хийгдэж байгаа гэдгийг анхаарна уу.

Юун түрүүнд энэ төслийг хариуцаж буй профессор Усүяма Тошинобү гуайг мэндчилгээ дэвшүүлж, энэхүү лекцийн зорилгыг товч танилцуулахыг хүсэж байна.

Усүяма Тошинобү (Цукубагийн их сургуулийн профессор): Сайн байцгаана уу, та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Өнөөдөр энэхүү лекцэд хүрэлцэн ирсэн та бүхэнд маш их баярлалаа. Одоо энэ лекцийн зорилгыг товч танилцуулья.

Цукубагийн их сургууль нь Ниппон сангийн дэмжлэгтэйгээр “Ниппон Сангийн Төв Ази - Японы Хүний Нөөц Хөгжүүлэх Төсөл” нэртэй томоохон хэмжээний хүний нөөцийн глобал төслийг хэрэгжүүлдэг. Энэ төслийн зорилго нь Төв Ази болон Японы хооронд чөлөөтэй харилцаж, Япон, Төв Ази, мөн дэлхийн нийгмийн хөгжилд идэвхтэй үүрэг гүйцэтгэх чадвартай хүний нөөцийг бэлтгэхэд оршино.

Лекцүүдийн хувьд, ирээдүйн ажил мэргэжлийн замналд хэрэгтэй практик сэдвүүдийг голчлон сонгосон байдаг бөгөөд тодорхой хязгаарлалт тогтоогоогүй хэдий ч манай их сургуулийн, ялангуяа Төв Азийн олон улсын оюутнууд болон Цукубагийн их сургуулийн япон оюутнууд Япон дахь нөхцөл байдал болон Төв Евразийн нийгэм дэх янз бүрийн асуудал, НҮБ-аас дэвшүүлсэн SDGs буюу Sustainable Development Goals хэмээх тогтвортой хөгжлийн зорилгуудад амжилттай хувь нэмэр оруулах зэрэг санаачлалыг илүү гүнзгий ойлгох боломжийг олгох үүднээс “Төв Еврази ба Японы Ирээдүй” нэртэй цуврал лекцүүдийг зохион байгуулж байна. Өнөөдөр энд бидэнтэй хамт нийгмийн эрүүл мэндийн чиглэлийн мэргэжилтэн профессор Ичикава Масао хүрэлцэн ирсэн байгаа.

Ингээд одоо микрофоноо буцаагаад Ямамото гуайд шилжүүлбэ гэж бодож байна. Баярлалаа.

Ямамото: Баярлалаа. Одоо өнөөдрийн 11 дэх удаагаа зохион байгуулагдаж байгаа “Төв Еврази ба Японы Ирээдүй” цуврал лекц унших профессор Ичикаваг танилцуулья. Профессор Ичикава их сургуулиа төгсөөд Таиландын Махидонийн их сургууль, Английн Уэльсийн их сургуульд аспирантурт суралцаж төгсөөд, дараа нь Үндэсний Олон Улсын Анагаах Ухааны Төв, Токиогийн их сургуульд зэрэг хамгаалж туршлага хуримтлуулсан бөгөөд одоогоор Цукубагийн их сургуулийн анагаах ухааны профессороор ажилладаг. Халдвар судлал, урьдчилан сэргийлэх анагаах ухаан, нийгмийн эрүүл мэнд, хүүхдийн судалгаа, анагаах ухааны социологи гэх мэт чиглэлээр мэргэшсэн бөгөөд нийгэм дэх төрөл бүрийн асуудлыг олон өнцгөөс зөвхөн Японд төдийгүй дэлхийн хэмжээнд шийдвэрлэх зорилгоор судалгаа хийдэг.

Өнөөдөр профессор Ичикава Их Британийн их дээд сургууль болон төрийн бус байгууллагатай (ТББ) хамтран зохион байгуулсан монгол хүүхдүүдийг түлэгдэх ослоос хамгаалах, амьдрах орчныг сайжруулах төслийн хүрээнд Төв Азийн гүрнүүдийн нэг болох Монгол Улсын талаарх жишээ судалгааг танилцуулах болно. Профессор Ичикаваг урьж байна.

Ичикава Масао (Цукубагийн их сургуулийн профессор): Та бүхэнтэй танилцахад таатай байна.

Намайг Ичикава гэдэг. Би Цукубагийн их сургуулийн анагаах ухааны салбар тэнхимд харьяалагддаг хэдий ч эмч эсвэл анагаахын мэргэжилтэн биш юм. Их дээд сургуулийн мэргэжлийг хүмүүнлэгийн ухаан, шинжлэх ухаан гэж хуваадаг бол би анх хүмүүнлэгийн ухааны хүн байсан бөгөөд олон улсын хамтын ажиллагаа болон хөгжиж буй орнуудын хөгжлийн асуудлыг сонирхож судалж ирсэн.

Одооноос 30 жилийн өмнө би анх их сургуульд ороод сурлага дажгүй байсан хэдий ч олон улсын хамтын ажиллагаа сонирхож байсан тул 1-р курсээсээ эхлээд ТББ-ын үйл ажиллагаанд сайн дураараа оролцож эхэлж байсан юм. Энэхүү ТББ нь Филиппиний хөдөө орон нутаг болон загас агнуурын тосгодод Казуса хэмээх гүний худгийг өрөмдөх технологийг дамжуулах чиглэлээр ажиллаж байсан бөгөөд үүнд би идэвхтэй хамрагдах болсон. Филиппиний хөдөө орон нутагт хүмүүс эрүүл ахуйн шаардлага хангаагүй 2~3 метр орчим ухааж гаргасан гүехэн худгийг хэрэглэдэг бөгөөд энэхүү худгийн ус нь хуурайшилтын улиралд ганддаг. Би тухайн үед иймэрхүү усан хангамж хангалтгүй газарт аюулгүй усан хангамж нийлүүлэх зэрэг ажлыг хийж байсан.

Азаар надад их сургуульд орсныхоо дараа шууд энэ төрлийн үйл ажиллагаанд оролцох боломж тохиож байсан хэдий ч сургуулийн хажуугаар бусад үйл ажиллагаанд бүрэн оролцох хэцүү байсан тул би их сургуулийнхаа 2-р

курсээ төгсөөд 20 настай байхдаа сургуулиасаа нэг жилийн чөлөө авч орон тооны сайн дурын ажилтнаар Филиппиний хөдөө орон нутаг болон загасчдын тосгонд ажиллаж амьдарч байсан. Би олон улсын хамтын ажиллагаа өрнүүлж байсан гэхээс илүүтэйгээр олон улсын хамтын ажиллагаа намайг хүмүүжүүлсэн гэж боддог.

Гүний худаг ухах үед газар доорх ус өөрөө гарч ирэх тохиолдол байдаг ба хүмүүс энэхүү усан дээр ирж хувцсаа угаахын зэрэгцээ ус авч мөн усанд орцгоодог. Үүнийг хөндлөнгөөс харахад хүмүүсийн амьдралд ашиг тус үзүүлж байгаа гэж харагддаг хэдий ч энэ нь нутгийн хүмүүсийн эрүүл мэнд болон амьдралын чанарыг үнэхээр сайжруулж байгаа эсэхийг тодорхойлоход хэцүү байдаг. Тиймээс би энэ төрлийн төслүүдийг дүгнэж үнэлдэг ажлын талаар сонирхох болсон юм. Тухайн үеэс хойш би олон нийтийн эрүүл мэндийн талаар судалж эхэлсэн. Би одоогоор төрөл бүрийн төслийн бодлогууд хүмүүсийн эрүүл мэндэд хэрхэн нөлөөлж байгаа талаар судлаад явж байна.

Өнөөдөр би та бүхэнд Монгол дахь бидний хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар танилцуулахыг хүсэж байна. Ингэж хэлэх үед хүмүүс ихэвчлэн “яагаад Монгол гэж?” хэмээн асууцгаадаг. Яагаад Монгол вэ гэхээр манай лабораторид Монгол оюутан ирсэн тохиолдол гарсан учраас юм. Бид Монголоос гадна Таиланд, Лаос, Шри Ланка, Непал, Вьетнам гэх мэт улс орнуудад ч гэсэн хамтын үйл ажиллагаа өрнүүлж ирсэн бөгөөд энэ нь ихэнхдээ олон улсын оюутнуудтай холбогдсоноос шалтгаалж байсан байдаг. Монгол дахь төслүүдийн хувьд ч мөн адил юм.

Би голчлон урьдчилан сэргийлэлтийн талаар судалгаа хийдэг. Түүрхэн хэлсэнчлэн манай лабораторид Монгол оюутан ирээд намайг юу судалдаг талаар мэдсэнээр Монголд гарч буй ослоудын талаар судалгаа хийхээр болж байсан юм. Монголд гарч буй ослоудын талаар судалгаа хийж байгаад Монголд хүүхдийн түлэгдэлт их байдгийг мэдсэн ба цаашид түлэгдэлтээс хэрхэн урьдчилан сэргийлэх вэ гэсэн сэдвээр судалгаа хийхээр шийдсэн.

Чухамдаа түлэгдэлт бол дэлхий даяар тулгарч буй эрүүл мэндийн томоохон асуудлуудын нэг юм. Японд хүмүүс осол аваар бол эрүүл мэндийн асуудал гэдгийг нэг их хүлээн зөвшөөрөөд байдаггүй. Гэхдээ ослын улмаас хүмүүс нас барж, бэртэж гэмтэж байдаг тул ослыг эрүүл мэндийн асуудал гэж тооцох ёстой юм. Түлэгдэлт нь дэлхийн хэмжээнд эрүүл мэндийн тулгамдсан асуудалд тооцогддог. Сүрьеэ, ХДХВ, хумхаа өвчнийг дэлхийн гурван том халдварт өвчин гэж нэрлэдэг боловч үнэндээ сүрьеэ, ХДХВ-ийн халдвар авсан хүмүүсийн тооноос ч олон хүн түлэгдэлтэд өртдөг. Дэлхийн хэмжээнд жилд 11 сая хүн гүн түлэгдэлтэд өртдөг ба эдгээрийн ихэнх нь хөгжиж буй орнуудад тохиолддог.

Монгол хүүхдүүдийн түлэгдэлтээс үүдэлтэй нас баралтын түвшин дэлхий дахинтай харьцуулахад өндөрт тооцогддог. Монголд 100 мянган хүн тутамд ноогдох таваас доош насны найман хүүхэд түлэгдэлтээс болж нас бардаг. Хөгжингүй орнуудад 100 мянгад нэг ч байдаггүй бөгөөд 0.3 орчим байдаг. Дэлхийн дундаж нь ойролцоогоор хоёр хүн байдаг тул түлэгдэлт бол Монгол дахь ноцтой асуудлуудын нэгт тооцогдох юм.

Энэхүү асуудлыг шийдэхийн тулд нэн тэргүүнд хийх ёстой зүйл бол одоогоор мэдэгдэж буй түлэгдэлтийн талаарх мэдээ, мэдээлэл, судалгаа зэргийг олж судлах явдал юм. Харамсалтай нь Монголд түлэгдэлтийн талаарх нэг их судалгаа хийгдээгүй байсан ба бид цөөн тооны баримт мэдээллийг олж авч чадсан.

Нэгдүгээрт, гэмтлийн эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байсан 5-аас доош насны хүүхдүүдийн 40 хувь нь түлэгдэлтээс болж эмнэлэгт хэвтэж байсан гэдгийг тодорхойлж чадсан. Мөн амбулаториор үйлчлүүлсэн хүүхдүүдийн 30 орчим хувь нь түлэгдсэнээс болж эмнэлэгт хандсан болохыг тогтоосон.

Мөн хүүхдийн түлэгдэлтийн талаар хийгдсэн өрхийн судалгаа байсныг олж авсан. Энэ нь Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод хийгдсэн судалгаа бөгөөд 5 хүртэлх насны 900 хүүхэд чиглэсэн судалгаа байсан. Судалгаанд хамрагдагсдын 30 орчим хувь нь урьд өмнө нь түлэгдэлтэд өртөж байсан бөгөөд үүнээс 19 хувь нь дор хаяж хоёр удаа, 84 хувь нь гэртээ, 40 хувь нь халуун ундаа, хоол хүнс, 30 хувь нь зуухнаас болж түлэгдэлтэд өртсөн байсан. Эдгээрийн дийлэнх нь хүүхдүүдийн дэргэд насанд хүрэгчид хамт байх үед тохиолдсон гэж мэдээлсэн байсан.

Түүнчлэн Улаанбаатар хотын 5-аас доош насны 100 мянган хүүхэд ногдох түлэгдэлтээс үүдэлтэй нас баралтын түлэгдсэн эх үүсвэрийн талаарх маш сонирхолтой судалгаа хийгдсэн байсан. Түлэгдэлтээс үүдэлтэй нас баралтын түлэгдсэн эх үүсвэрийг утаа, гал түймэр, галын дөл, болон халуун болон өндөр температурын зүйлтэй харьцах, гэж хуваасан байсан. Халуун болон өндөр температурын зүйл гэдэг нь халуун ундаа, хоол хүнс болон зуухыг хэлэх ба 2008 оноос хойш эдгээрээс үүдэлтэй нас барсан хүний тоо эрс нэмэгдсэн байсан. Өөрөөр хэлбэл 2007~2008 оны хооронд ямар нэгэн зүйл болсон гэдгийг энэ графикаас харж болох юм.

Гэхдээ бид эдгээр статистик тоо баримт, судалгаатай танилцсаны дараа ослоос урьдчилан сэргийлэх ямар арга хэмжээ авч байгаа, ямар нөхцөлд осол гарч байгаа зэргийг дэлгэрэнгүй мэдэх боломжгүй байсан. Өөр үүнтэй холбоотой судалгаа мэдээлэл хомс байсан тул бид ослын бодит байдлыг тодруулах үүднээс Гэмтэл Согог Судлалын Үндэсний Төв дээр судалгаа хийхээр шийдсэн юм.

Гэмтэл Согог Судлалын Үндэсний Төв нь Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод байрлах бөгөөд Монголын

өнцөг булан бүрээс ослоор гэмтсэн хүнд өвчтөнүүд ийшээ тэвэрлэгдэж ирдэг. 2015 оны 8-р сараас хойш нэг жилийн хугацаанд бид энэ эмнэлэгт түлэгдэлтийн улмаас хэвтсэн 15-аас доош насны хүүхдүүдийн дунд судалгаа хийхээр шийдсэн юм. Бид эмнэлэгт хэвтэн эмчлүүлж буй хүүхдүүдийн эцэг эхтэй ярилцлага болон асуулга ашиглан мэдээлэл цуглуулсан ба мөн эмнэлгийн бүртгэлээс ч гэсэн шаардлагатай мэдээллийг цуглуулсан.

Ярилцлагын үеэр бид хүүхэд түлэгдсэн үеийн нөхцөл байдал ямар байсан талаар, түлэгдэлтийн эх үүсвэр юу байсан талаар, хүүхэд түлэгдэлтийн эх үүсвэрт хэрхэн хавьтсан талаар асуусан. Мөн түлэгдэлтийн ямар эх үүсвэр гүн түлэгдэхэд хүргэдэг талаарх мэдээллийг олж авч чадсан бөгөөд эдгээр мэдээллүүдийг тодорхойлсны эцэст гүн түлэгдэхээс урьдчилан сэргийлэх талаарх арга хэмжээг олж гаргасан. Дэлгэрэнгүй мэдээллийг судалгааны бичгээс харна уу.

Судалгаа хийсэн нэг жилийн хугацаанд нийт 906 хүүхэд эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн. Эдгээр хүүхдүүдийн дийлэнх нь 3-аас доош насны хүүхдүүд, тэр дундаа дөнгөж мөлхөж эхэлж байгаа 1 настай хүүхдүүд байсан. Эдгээр хүүхдүүдийн түлэгдэлтэд өртсөн шалтгаан нь ихэвчлэн халуун ус болон халуун шөл гэх мэт халуун шингэнээс болсон байсан. Үүнээс гадна Монголд хүмүүс сүүтэй цайг их хэмжээгээр халуун саванд хийж байнга ууж байдаг. Хүүхдүүдийн 90 гаруй хувь нь сүүтэй цайнд хүрч түлэгдсэн байсан нь тогтоогдсон.

Хамгийн их магадлалаар түлэгдэх осолд өртсөн хүүхдүүд бол “монгол гэр”-т амьдардаг хүүхдүүд байсан бөгөөд нийт түлэгдсэн осол гэмтлийн 50-аас дээш хувь нь монгол гэрт тохиолдсон байсан. Гэрт хүмүүс нэг өрөөнд хоол хийх, унтах, зурагт үзэх, амрах гэх мэт зүйлсийг хийдэг бөгөөд энд түлэгдэх осол хамгийн их тохиолддог гэдгийг тогтоож чадсан.

Түлэгдэх осол гарсан үеийг харахад Монголд өвөл урт үргэлжилдэг учраас өвөл тохиолддог гэж бодож магадгүй ч улирлын ялгаа байгаагүй. Осол гарсан цагийг харахад ихэвчлэн өглөө, өдөр, оройн хоолны үеэр их тохиолддог болохыг олж мэдсэн.

Нийт түлэгдлийн тохиолдлын 90 гаруй хувь нь халуун шингэн зүйлсэд түлэгдсэн тохиолдлууд байсан. Халуун шингэний эх үүсвэрийн 40 хувь нь том цахилгаан тогоо, 14 хувь нь ус буцалгагч байсан байгаа юм. Нийт эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байсан 906 хүүхдийн 601 нь гүн түлэгдсэн байсан ба эдгээрийн 310 нь буюу 52 хувь нь цахилгаан тогооноос болж түлэгдсэн байсан. Өөрөөр хэлбэл хэрвээ Монголд цахилгаан тогоо байгаагүй бол эдгээр хүүхдүүдийг гүн түлэгдэлтээс урьдчилан сэргийлэх бүрэн боломжтой байсан гэсэн үг юм. Түүнчлэн цахилгаан тогоонд түлэгдсэн 373 түлэгдэлтийн 310 нь гүн түлэгдэлтэй байсан. Энэ нь цахилгаан тогооноос үүдэлтэй түлэгдэлтийн

ихэнх нь гүн түлэгдэлт байдаг гэдгийг харуулж байгаа юм.

Хүүхдүүд чухам хэрхэн түлэгдсэн бэ гэхээр...цахилгаан тогоо мөргөж, доторх шингэнийг асгаж эсвэл ус буцалгагч, халуун сав өөр дээрээ татан унагааж түлэгдсэн байсан.

Энэхүү судалгааны эцэст цахилгаан тогооноос үүдэлтэй ослын эсрэг арга хэмжээ авах хэрэгтэй гэдэг нь ойлгомжтой болсон. Монгол гэрт гал тогоо гэж тусдаа байдаггүй бөгөөд цахилгаан тогоо тавих газар байдаггүй тул ихэвчлэн шалтай ойр ширээ юм уу сандал дээр тавьж ашигладаг.

Би анх монгол гэр дотор хүмүүс ямар ч хаалтгүйгээр зуух хэрэглэдэг учир түүнээс болж хүүхдүүд түлэгддэг байх гэж бодож байсан. Мэдээж хэрэг зууханд түлэгддэг хүүхдүүд их байдаг боловч зуух нь маш том учраас нүдэнд ил харагддаг. Нөгөөтэйгүүр, цахилгаан тогоо нь жижиг бөгөөд шалан дээр тавьдаг тул хүүхдүүд мэдэлгүйгээр шууд хүрчихдэг байна. Энэ нь түлэгдэх осол тохиолдох шалтгаан болдог гэдгийг энэ удаагийн судалгаанаас олж мэдсэн юм.

Манай лабораторийн Монгол оюутан интернетээс цахилгаан тогоог аюулгүй ашиглах талаарх тавилгын дизайн байсныг олж харсан. Энэ тавилгын дизайныг хүүхдээ түлэгдэлтээс болж алдсан эцэг эх гаргасан ба тэдний “ийм тавилга байсан ч болоосой” гэсэн хүслийн хүрээнд бүтээгдсэн байсан. Өөрөөр хэлбэл энэ тавилга нь цахилгаан тогоог аюулгүй ашиглах талаар арга хэмжээ авах хэрэгтэй гэдгийг харуулсан ил тод жишээ юм.

Түүнчлэн монгол оюутан маань интернетээс цахилгаан тогоог хаших гар хийцийн тавилга байдгийг олж харсан. Энэ тавилга нь жирийн дэлгүүрт зарагддаггүй боловч энэ төрлийн тавилга хийдэг хувь хүмүүс байдаг ба энэхүү жишээ нь тавилгыг авах эрэлт мөн байдаг гэдгийг харуулж байгаа юм.

Үүнээс гадна монгол гэрийн багана дээр цахилгаан тогоог тавьж болох тавиурыг зохиосон санаа байсан. Энэ нь түлэгдэлтийн ослыг бууруулах зорилгын үндсэнд гаргаж байсан Гэмтэл Согог Судлалын Үндэсний Төвийн нэгэн эмчийн санаачилсан төсөл байсан. Харамсалтай нь энэ санаа нь амжилттай үр дүнд хүрээгүй. Шалтгаан нь тус тогооны тавиурын өндөр нь насанд хүрсэн хүний бэлхүүсний өндөртэй тэнцүү буюу хүүхдийн толгойн өндөртэй чацуу байсан байгаа юм. Тиймээс хүүхэд тавиурт толгойгоо цохих, түлэгдэх зэрэг аюулууд гарч болохуйц байсан тул энэ төсөл нь цуцлагдсан.

Би худаг ухаж чадах боловч тавилга хийж чадахгүй. Тиймээс тавилга үйлдвэрлэгч Нитори компаниас хамтран ажиллахыг хүсэж 2017 оны 3-р сард Ниторигийн ерөнхийлөгчид захидал бичсэн юм. Захидал явуулснаас хэсэг хугацааны дараа Ниторигийн ажилтнаас миний саналын талаар илүү дэлгэрэнгүй ярилцахыг хүссэн тухай хариу ирсэн тул би 3-р сарын сүүлчээр Ниторигийн Токио дахь төв оффис уруу очиж уулзахаар явсан. Уулзалт дээр

би “Хүүхдийг түлэгдэлтээс хамгаалах гал тогооны хувьсгал!” гэсэн гарчигтай бүдүүвч зураглал авч очиж төслийн зорилгыг тайлбарласан. Намайг өөрийн саналаа тайлбарласны дараа бид шууд хамтран ажиллах талаар санал нийлж, Ниторигийнхан цахилгаан тогоо тавих зориулалтын тавиурын загварыг гаргаж өгөхөөр болсон юм.

Загвар хийгдсэн даруй би монгол оюутныхаа хамт Ниторигийн Токио дахь төв оффис дээр очиж уулзсан. Үнэнийг хэлэхэд анх тэдний хийсэн загварыг хараад ихэд цочирдсон. Яагаад гэвэл тэр загвар бидний төсөөлж байснаас тэс өөр байсан. Гэвч энэ нь яах ч аргагүй байсан. Би Ниторигийнханд түрүүн хэлсэн гар хийцийн тавилгыг үзүүлж, үүнтэй төстэй загварыг 30 доллар аар хийж өгөөч гэж хүссэн юм. Бидний зүгээс энэ компаниас туслалцаа хүссэн тул загварын талаар нарийн захиалга хэлэхэд хэцүү байсан. Миний захиалсан цорын ганц зүйл бол үнэ хямд байх хэрэгтэй гэсэн зүйл байсан. Хэрэв үнийн хувьд хямд биш бол тавиурыг орон нутгийн айл өрхүүдэд хэрэглүүлэх боломжгүй болох байсан тул тавиурыг 30 доллар аар хийж өгөхийг хүссэн юм. Гэвч эцсийн бүтээгдэхүүн 40 гаруй доллар болсон байсан.

Би яаж тавиурын дизайныг нь сайжруулж бас хямд болгох талаар бодож яваад Токиод байрлах Ниторигийн салбар дэлгүүрт орж тавилга хайсан юм. Тэгж явж байгаад бэлэн дэлгүүрт зарагдаж байгаа тавилга ашиглавал арай хямд тусч шинэ тавилга хийх гэж зовох шаардлагагүй гэж бодсон.

Тавилга хямд байхын тулд бөөнөөр үйлдвэрлэгдэх хэрэгтэй байдаг. Бөөнөөр үйлдвэрлэгдэхийн тулд хэв хийх шаардлагатай байдаг ба энэхүү хэвийг хийхэд багагүй мөнгө зарцуулдаг. Ниторигийнхан анхны загварыг хэв ашиглалгүйгээр хийсэн байсан тул олон асуудалтай тулгамдсан байсан.

Ниторигийн дэлгүүрт явж байхад ган тавиур миний нүдэнд туссан. Ган тавиур харьцангуй хямд байдаг тул үүнийг ашиглавал арай хямд тусна гэж бодсон ба дахин Ниторигийнхантай уулзахаар шийдсэн.

Энэ удаад харин би хүссэн дизайныхаа талаар илүү нарийн загварыг хэлэх хэрэгтэй гэж дүгнэсэн тул ган тавиурынхаа дизайныг жаахан өөрчилж, цахилгаан данх зэрэг бусад жижиг зүйлс хаана орохыг тодотгосон илүү тодорхой санал тавьсан.

Үр дүнд нь яг төсөөлсний минь дагуу бүтээгдэхүүнийг маань хийж өгсөн. Энэ бүтээгдэхүүнээ бид “гал тогооны тавиур” гэж нэрлэсэн. Гэхдээ үнэндээ Ниторигийн дэлгүүрт бидний хүссэн хэмжээний тавиур байгаагүй тул Ниторигийнхан өөр компанийн тавиур захиалж түүнээс жишээ авч бидний загварыг хийж өгсөн байсан. Хүүхдийг түлэгдэлтээс хамгаалахын тулд хүүхдийн гар цахилгаан тогоонд хүрч чадахгүй байх шаардлагатай байсан учраас



Зураг 1

энэхүү тавиурыг хүүхдийн гар хүрэхээргүй өндөр болон гүнтэй байхаар хийсэн.

Би анх 2018 оны 11-р сард гал тогооны тавиураа Монголд аваачсан. *Зураг 1-т* гэрийн дотор талыг харуулсан байгаа бөгөөд цахилгаан тогоо, ус буцалгагчийг намхан ширээн дээр тавьсан байгааг харж болно. Энэ гэрийн ээжээс хүүхдүүд нь цахилгаан тогоонд түлэгдэх магадлал хэр байдаг талаар асуухад тэр өдөр бүр гэж хариулсан. Энэ гэрт гурван охин байдаг ба ээж нь тэднийг түлэгдэхвий гэж байнга санаа зовдог гэж ярьсан.

Би энэ айлд анхны гал тогооны тавиураа ашиглуулж үзэхээр шийдсэн. Тавиураа хаана тавьсан вэ гэхээр Монголд монгол гэрийн багана дундуур алхвал гэр бүлийн холбоо тасарна гэсэн итгэл үнэмшил байдаг тул баганын хооронд байнга ашиглагддаггүй зай байдаг. *Зураг 2-т* үзүүлсний дагуу бид тэр зайд гал тогооны тавиураа байрлуулахаар шийдсэн.

Гал тогооны тавиурыг нэг сар хэрэглэсний дараа гэрийн ээж тавиурын доод талд хаалга байхгүй зай гарсан байсан тул хүүхдүүд тэнд орж тоглох болсон гэж ярьсан. Мөн хүүхдүүдийг тавиурын доор оруулж тоглуулахгүйн тулд тавиурын доод хэсэгт хаалт байх хэрэгтэй гэсэн санал авсан. Үүнээс гадна тавиурын өндөр 90 см байсан тул жаахан том санагдсан ба бага зэрэг жижиг байсан нь зүгээр гэсэн санал дэвшүүлсэн. Иймэрхүү жижиг сайжруулах шаардлагатай хэсгүүд багагүй гарсан ч энэхүү гал тогооны тавиурыг ашигласнаар хүүхдүүд түлэгдэхвий гэсэн санаа зовнил багассан гэсэн юм.



Зураг 2

Энд танилцуулсан шиг тавиурыг гадаадаас аваачихаас илүүтэйгээр дотооддоо байгаа тавилгыг ашиглах нь дээр байх гэж бодоод хөдөө орон нутгийн дэлгүүрээс адилхан ашиглаж болохоор тавилга байгаа эсэхийг хайсан боловч Японд хийсэн шиг бат бөх загвартай тавилга олж чадаагүй.

Би гал тогоонд хэрэглэх тавилга гэж бодоод дандаа гал тогоонд зориулсан бэлэн тавилга хайгаад байсан боловч Японд буцаж ирээд интернет дэлгүүрээс хайж байгаад гал тогоонд зориулагдаагүй бусад тавилгыг ч гэсэн ашиглаж болохыг ойлгосон. Ялангуяа хувцас хадгалах зориулалттай шүүгээг ашиглах боломжтой гэж бодоод Зураг 3-т харагдах тавилгыг захиалсан бөгөөд үүнийг 6 мянган иенээр худалдаж авсан. Өндөр нь хүрэлцэхгүй хөл нь гүйлгэгчтэй учир тогтворгүй байсан хэдий ч иймэрхүү тавилга байх нь зүгээр юм байна гэж бодогдсон.

Гэхдээ дангаараа хэтэрхий энгийн байсан тул би 100 иений дэлгүүрээс нэмэлт зүйл худалдаж авч тавилга дээрээ нэмсэн. Ялангуяа тавилгынхаа дээд хэсгийг өөрчилсөн бөгөөд үүнийгээ Ниторигийнханд үзүүлж иймэрхүү загвартай тавилгыг хийж өгөөч гэж гуйсан.

Үүний үр дүнд Ниторигийнхан бидэнд Зураг 4-т харагдах тавилгыг хийж өгсөн. Тавиурын доод талд хаалга хиймээр байсан ч төсөв хүрэлцэхгүй байсан тул хаалгагүй хийсэн. Мөн өмнө нь тавиурыг туршиж үзсэн айл тавиурын хэмжээг арай том байна гэж хэлсэн тул тавиурын өндөр, урт, өргөнийг бага зэрэг богиносгосон.

Тавиурын хажуу талыг зориуд тороор хийлгүүлсэн. Шалтгаан нь тавиурын дотор тал харагдахгүй бол хүүхэд



Зураг 3



Зураг 4

дотор нь юу байгааг сонирхож авирахаар оролдож магадгүй гэж бодсон юм. Үүнээс гадна энэ нь зардлыг бууруулахад нэмэр болсон. Ингэснээр хүүхэд торны нүхээр хуруугаа хийж мэдэх боловч энэхүү тавиурын загвар нь доторх цахилгаан тогоо болон ус буцалгагчид хүүхдийн гар хүрэхгүй байхаар хийгдсэн байгаа.

Хүүхдийн хуруу санамсаргүй тогоонд хүрсэн ч хурууны үзүүр л бага зэрэг түлэгдэх бөгөөд энэ нь тийм ч том асуудалд тооцогдохгүй гэж бодож байна. Яагаад гэвэл

хүүхэд өсөж том болохын тулд бага зэрэг өвдөлт мэдэрч түүнээс суралцах нь чухал байдаг. Харин бидний зайлшгүй урьдчилан сэргийлэх ёстой зүйл бол хүнд хэлбэрийн түлэгдэх осол юм.

Энэхүү тавиур маань 20 кг жинтэй тул хүүхдүүд цохисон ч хөдлөхгүй. Насанд хүрсэн хүн цохисон ч тавиур маань квадрат хэмжээтэй нэлээд тогтвортой тул тийм ч амархан унахгүй.

Хэдийгээр тавилгыг хийсэн боловч энэ тавилга нь үнэхээр түлэгдэлтийн эрсдэлийг бууруулж чадах уу гэдэг асуудал тулгамдсан. Түлэгдэлтийн эрсдэлийг бууруулах эсэхийг бүрэн мэдэхгүй байж гал тогооны тавиурыг борлуулах нь утгагүй тул тавиур борлуулах үр нөлөөг хэмжих талаар төлөвлөж байгаа. Энэхүү төлөвлөгөө маань хэдийнээ Судалгааны Ёс Зүйн Хорооны хяналтаар орсон ба клиникийн туршилтын бүртгэлийн газарт бүртгэгдсэн байгаа.

Мөн энэхүү тавиур маань өндөр үнэтэй бол орон нутагт худалдаалагдаж чадахгүй тул нутгийн иргэдийн худалдан авч чадахуйц үнээр борлуулах шаардлагатай. Өөрөөр хэлбэл тавилгыг зарахад тохирох үнэ хэд вэ гэдгийг эцэслэхийн тулд бид одоо санал асуулга бэлтгэж байгаа.

Гал тогооны тавиур нь энгийн нэг тавилга боловч үнэндээ маш хатуу шалгуур бүхий чанарын хяналтад орж бүтээгддэг. Ниторигийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл хариуцдаг мэргэжилтний хэлснээр бүтээгдэхүүнүүдийн анхны загварыг гаргахдаа техникийн үнэлгээний холбоогоор оруулж хянуулдаг гэж ярьсан. Жишээлбэл, бид анх тавиурын хажуу талыг тороор хийхийн оронд төмөр тавцанг цоолсон мэт загвараар хийе гэж бодож байсан боловч энэ тохиолдолд цоолсон хэсэг нь хурц учраас хүүхэд хуруугаа нүхэнд хийж гэмтэх магадлал ихтэй байсан. Түүнчлэн цахилгаан тогооны залгуур нь Японы залгуураас арай том тул торны булангийн хэсгийг зүсээд бага зэрэг зай онгойлгоно гэж бодож байсан ч энэ тохиолдолд хүүхэд торны онгойсон хэсэг дээр хуруугаа гэмтээж болзошгүй байдал үүсэхээр байсан. Техникийн үнэлгээний холбоо нь иймэрхүү гэмтэж болзошгүй магадлалуудыг урьдчилан тооцоолдог. Үүнээс гадна бүтээгдэхүүн чухам ямар тохиолдлуудад унаж болох эсэхийг шалгадаг тест, мөн гуравдагч этгээдэд даалгасан үзлэг бас хийгддэг. Бүтээгдэхүүний бүртгэл нь эдгээр процессоор дамжигдан хийгддэг байна.

Тавиураа хийж чадсан боловч бидэнд одоо тус тавиурын түлэгдэлтийн эсрэг үр нөлөөг хэмжихэд хэрэгтэй төсвийн асуудал тулгамдаад байгаа ба одоог хүртэл санхүүжилт олж чадалгүй явна.

Эхэндээ би энэ төслийг судалгаа маягаар хийнэ гэж бодож байсан тул 2016 оны 10-р сард Какен буцалтгүй санд санхүүжилт авах хүсэлт гаргаж байсан. Би энэхүү сангаас заавал судалгааны төсөв авч чадна гэдэгтээ

итгэлтэй байсан боловч 2017 оны 4-р сард сангаас санхүүжилт олгохоос татгалзсан хариу ирсэн. Татгалзсан хариу ирсэн тохиолдолд судалгааны хүсэлтэд оноо өгч дүгнэдэг бөгөөд А нь дээд 25 хувь, В нь дараагийн 25 хувь, С нь доод 50 хувь байдаг. Миний судалгаа С дүнтэй байсан. Ингээд би ийм төсөл Какен сангаар үнэлэгдэхгүй гэдгийг ойлгосон тул энэхүү сангаас санхүүжилт хүсэхээ болихоор шийдсэн юм.

Үүний дараа би JICA олон улсын анхан шатны техникийн хамтын ажиллагааны төсөлд хамрагдах боломжтой гэдгийг олж мэдээд 2017 оны 6-р сард их сургуулиараа дамжуулан өргөдөл гаргасан. Өргөдөл гаргахдаа JICA-гийн ажилтантай хамт зөвлөлдөж, зөвлөгөө авч саналаа боловсруулсан тул энэ удаад үнэхээр боломжтой гэж бодсон хэдий ч энэ удаад бас татгалзсан хариу ирсэн.

JICA-гийн төсөлд жилд хоёр удаа өргөдөл гаргаж болдог тул би дахин өргөдөл гаргасан ба энэ удаад эцсийн шалгаруулалт хүртэл үлдэж чадсан боловч сүүлийн шатанд тэнцээгүй. Төслийн ирээдүйн тогтвортой байдал нь баталгаагүй байсан тул тэнцэж чадаагүй. Төслийн тогтвортой байх үндэслэлийг харуулахын тулд судалгаа хийх шаардлагатай байсан ба би энэхүү судалгааг санал дотроо оруулсан байсан боловч үүнийг хүлээн зөвшөөрөөгүй. Төслийн талаар үндэслэлгүй мэдээлэл хэлж болохгүй тул анхан шатны техникийн хамтын ажиллагааны төслийг ч гэсэн болихоор шийдсэн юм.

Дараа нь би краудфандинг ашиглан хөрөнгө босгох талаар бодож үзсэн. Цукубагийн их сургууль нь READYFOR нэртэй краудфандинг компанитай гэрээтэй тул READYFOR-тай зөвлөлдөж үзсэн. Гэсэн хэдий ч даруй болихоор шийдсэн. Учир нь краудфандинг ашигласан тохиолдолд үр дүнг хагас жил эсвэл жилийн дотор гаргаж, хөрөнгө оруулагчдад тайлан тавих шаардлага гардаг. Миний төсөл бэлтгэл ажил оруулбал 2-3 жил шаардагдах бөгөөд үүнийг хагас жил эсвэл нэг жилийн дотор хэрэгжүүлнэ гэдэг нь боломжгүй зүйл юм. Тиймээс краудфандинг ашиглахаас ч гэсэн татгалзахаар болсон юм.

Нөгөөтгээгүүр, Монголтой холбоотой компанитай хамтран ажиллая гэж бодоод JICA-гийн төсөлд өргөдөл гаргахын зэрэгцээ Монгол дахь нэгэн компанитай хэлэлцээр хийж эхэлсэн. Тус компани бидэнтэй санхүүгийн хамтын ажиллагаагаа эхлүүлэх төлөвтэй байсан бөгөөд 2019 оны 1-р сард Монголд очих үед албан бус тохиролцоо хэлэлцэж чадсан. Гэсэн хэдий ч яг ажлаа эхлүүлэх гэж байхад тус компанийн нөхцөл байдлаас болоод санхүүгийн дэмжлэг авч чадахааргүй байдалд хүрсэн. Үүнийг бид 2019 оны 4-р сард олж мэдсэн ба тэр үед маш их сэтгэл гонсойж байсан.

Гэсэн ч бид бууж өгөлгүй олон газраас хамтын ажиллагааны талаар асууж хайсан. Жишээлбэл, Монгол сумогоор алдартай тул ёкозүнатай холбоо барьсан. Мөн

түүнчлэн гоо сайхны мэс заслын томоохон компаниас хүртэл санхүүгийн чиглэлээр хамтран ажиллах талаар асууж үзсэн. Эдгээр нь 2019 оны 7-р сарын явдал байсан хэдий ч эцэстээ бид хөрөнгө босгож чадаагүй.

Дотоодын хөрөнгө оруулалт болохгүй бол гадаадын хөрөнгө оруулалт гэж бодоод нэлээд судалсны эцэст Английн Уэльсийн Суонсигийн их сургуульд Олон Улсын Түлэгдэлт Судлалын Төв хэмээх хөгжиж буй орнуудад түлэгдэлтийн эсрэг урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч мөн түлэгдэлтийн эмчилгээ хийдэг төв байдгийг олж мэдсэн. Тэгээд тус төвтэй холбоо барьж төслийн зорилгоо тайлбарлаж санхүүгийн чиглэлээр хамтран ажиллахыг хүссэн. Надад энэ төвд танил байгаагүй хэдий ч судалгааныхаа талаар шаргуу хичээнгүй тайлбарлаж скайп-аар хоёр удаа ярилцсаны эцэст тус төвтэй хамтран ажиллахаар болсон. Үүний дараа 2020 оны 3-аас 4-р сар хүртэл туршилтын судалгаа хийхээр байсан боловч шинэ төрлийн корона вирусийн тархалттай холбогдуулан туршилтыг хойшлуулахаар болсон.

Цаашид яах вэ гэж бодсон үед, дөнгөж төсвөө олчихоод ингээд судалгаагаа зогсоож болохгүй гэж бодсон тул 2020 оны 6-р сард орон нутгийн иргэдтэй хамтран туршилтын

судалгааг эхлүүлсэн. Энэхүү судалгаа нь гэрт амьдардаг 50 айлд чиглэсэн судалгаа бөгөөд айл бүртэй ярилцлага хийж тавиураа суурилуулсан. Эдгээр зургууд нь энэ үеийн үйл явцыг харуулсан зураг болно.

Зураг 5-т гэрийн дотор талыг харуулсан байгаа бөгөөд энэ айл нь цахилгаан тогоог намхан ширээн дээр тавьж хоол хийж байсан. Гэрт амьдардаг ихэнх хүмүүс ийм маягаар хоол хийдэг бөгөөд заримдаа шалан дээр тогоог тавих тохиолдол гардаг.

Зураг 6-д ингэж шалан дээр цахилгаан тогоог тавихад тохиолдож болзошгүй аюулыг харуулсан байна. Зурагт харагдаж байгаа энэ айлын хүүхэд бүсэлхийн доошоогоо улайж түлэгдсэн харагдаж байгаа бөгөөд шалан дээр байсан цахилгаан тогоон дээр суусны улмаас түлэгдсэн байсан. Гал тогооны тавиурыг хэрэглэсэн байсан бол ийм харамсалтай осол хэзээ ч тохиолдохгүй байсан юм.

Зураг 7-д өөр нэг айлыг харуулсан байна. Тавиур дээр харагдах хоёр саваа нь тавиур доторх цахилгаан тогоог хөдлөхөөс сэргийлэх зориулалттай юм. Айл бүрийн тогооны хэмжээ янз бүр байдаг тул ингэж тавиур дээр саваа бэхэлсэн байсан.

Зураг 8-д хүүхдүүд тоглож байгааг харуулсан байна. Хүүхдүүд камерын өмнө томоотой байдаг ч бусад үед ялангуяа гэр дотор тоглох үед маш их аюултай байдаг. Гэвч гал тогооны тавиуртай байхад хүүхэд үүнийг цохисон ч ноцтой хэмжээний түлэгдэлтэд өртөхгүй болох юм.

Урьд нь тавиурын хэмжээ арай өндөр байна гэж ярьж байсан тул анхны хэмжээнээс арай намхан болгосон. Гэсэн хэдий ч *Зураг 9-д* харагдаж байгаа шиг тавиур өндөр ч байсан нам ч байсан хүүхэд нэг сонирхвол сандал дээр гарч дотор талыг нь харах гэж оролдоно. Ингэх нь аюултай хэдий ч энэ айлын ээжийн хэлж байгаагаар хүүхэд халуун



Зураг 5



Зураг 6



Зураг 7



Зураг 8



Зураг 9

тогоонд хүрч гүн түлэгдэж байснаас бага зэрэг түлэгдэх нь арай дээр гэж ярьсан.

Одоогийн байдлаар бид нэмэлт судалгаа хийж байгаа бөгөөд тавиурын ашиглалт, сайжруулалтын талаар хэрэглэгчдээс асуулга авч байгаа. Мөн хэрэглэгчдэд тохиромжтой үнийн талаар судалгаа хийж байгаа ба энэ судалгаагаар тавиурын үнэ хэд байвал худалдан авахад тохиромжтой вэ гэдгийг тооцоолох болно. Тавиурын үнэ ойролцоогоор 4 мянган иен байхад хүмүүсийн тал гаруй нь худалдаж авах магадлалтай гэж тооцсон учир үүнээс хойш энэ үнийг хэрхэн бууруулах талаарх асуудал үүснэ гэж бодож байна.

Цаашид туршилтын судалгааны үр дүнг ашиглан

тавиурын үр нөлөөг хянаж шалгах ажиллагааг хийх төлөвлөгөөтэй байгаа ба хэрэгтэй санхүүжилтийг үргэлжлүүлэн хайх болно. Мөн ирээдүйд тавиурын үнийг бууруулж, тогтвортой үйлдвэрлэж борлуулах асуудлууд үүснэ гэж харж байна.

Өнөөдрийн лекцийг ингээд дуусгаж байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Ямамото: Монгол дахь “Гал тогооны хувьсгал” төслийн талаар ярьсан профессор Ичикава танд баярлалаа.

Бидний өдөр тутамдаа хэрэглэдэг гал тогооны хэрэгслийг Монголын монгол гэрт амьдардаг хүмүүс ашиглахын тулд тусгай аргачлалын дагуу хэрэглэхгүй бол аюултай гэдгийг маш сайн харуулсан сонирхолтой ухаарал өгсөн яриа байлаа.

Одоо бидэнд 10 минут орчим хугацаа үлдсэн байгаа тул нийт сонсогчдоосоо асуулт болон сэтгэгдэл хүлээн авахыг хүсэж байна. Өнөөдрийн яриатай холбоотой асууж тодруулах зүйлс байвал асууцгаана уу.

Тастанбекова Куаныш (Цукубагийн их сургуулийн туслах профессор): Уучлаарай. Асуулт асууж болох уу?

Ямамото: За, асууна уу.

Тастанбекова: Намайг Тастанбекова Куаныш гэдэг. Би Казахстанас ирсэн бөгөөд Цукубагийн их сургуулийн хүмүүнлэгийн шинжлэх ухааны салбарт багшилдаг. Үнэхээр урамтай сайхан яриа өрнүүлсэн профессор Ичикава танд маш их баярлалаа.

Лекцийн эхний слайд дээр түлэгдэх осол ихтэй орнуудын тухай газрын зургийг харуулах үед Казахстан бас улаан өнгөтэй байгааг анзаарсан. Хэдийгээр Монгол Улсын хэмжээ шиг биш боловч Казахстан улсад ч мөн хүүхдийн түлэгдэлт бусад орнуудтай харьцуулахад харьцангуй өндөр байдаг гэдгийг ойлголоо.

Тэгээд би слайдад үзүүлсэн тавиурыг хийх заавар нь маш хялбар юм байна гэж харлаа. Казахстанд гар хийцийн тавилга маш их зарагддаг бөгөөд тавилгыг ихэвчлэн Баян-Өлгийд амьдарч байгаад буцаж ирсэн Казахууд хийсэн байдаг. Тиймээс би монголчууд тавилга хийхдээ гаргууд сайн байдаг гэж төсөөлдөг.

Өөрөөр хэлбэл би тавиурыг Японд хийж байхаар Монголд хийх боломжтой юм болов уу гэж бодлоо. Тавиурыг бэхлэхийн тулд хийсэн байсан саваа зэргийг ч мөн Монголд бизнес болгон хийж борлуулах боломжтой гэж бодож байна. Тавилга хийх заавар нь хялбар тул Японд санхүүжилт гарган монгол айлуудын худалдан авч чадахуйц үнээр үйлдвэрлэн авчирч байснаас илүүтэйгээр Монголд үйлдвэрлэсэн нь дээр юм болов уу гэж бодож байна. Үүний талаарх таны бодлыг асуух гэсэн юм. Баярлалаа.

Ичикава: Асуулт тавьсанд маш их баярлалаа. Нэгдүгээрт, Японы тавилга үйлдвэрлэгчээс төсөлд хамтарч ажиллахыг

асуусан хамгийн том шалтгаан нь аюулгүй байдлыг хангах явдал байсан. Хэрэв сая ярьсан аргаар тавилга хийж хүмүүс хэрэглэж байх үед том хэмжээний түлэгдэлтэд өртвөл энэ нь хамтран ажиллаж байгаа бидний хариуцлага ба байж болшгүй асуудал юм. Тиймээс яасан ч осол аваар гаргахааргүй тавиур хийхийн тулд нүүр тулж ярилцах боломжтой байсан Японы тавилга үйлдвэрлэгч компанитай зөвлөлдсөн юм.

Хэрэв боломжтой бол тавилгаа Монголд үйлдвэрлэхийг эрмэлзэж байгаа боловч одоогоор хамтран ажиллах түнш байхгүй байна. Мөн Монголд зарагдаж байгаа тавилгын дийлэнх нь Хятадад үйлдвэрлэсэн байдаг ба энэ нь үнэ хямд байдагтай холбоотой. Гал тогооны тавиурыг ч гэсэн Хятадад үйлдвэрлэж Монгол уруу импортлох нь хямд тусах болов уу гэж бас бодож байгаа.

Гэхдээ дотоодын үйлдвэрлэлийг дэмжих гэдэг утгаар нь Монголд үйлдвэрлэх нь дээр тул цаашдаа дотоодод үйлдвэрлэж болох эсэхийг судалж, аль болох дотоодод нь хийхийг хичээх болно.

Тастанбекова: Монголын дотоодын компанитай хамтарч Дэлхийн Банк, Азийн Хөгжлийн Банкнаас хүүгүй зээл авах гэх мэт санхүүжилт босгох боломжтой гэж бодож байна. Мөн Японы арга технологийг ашиглаж Монгол дотроо хийх нь хамгийн тохиромжтой шийдэл юм болов уу гэж бодогдлоо.

Ичикава: Маш их баярлалаа. Одоогоор бид энэхүү тавиурыг ашигласнаар түлэгдэлтийн аваар ослыг хэр зэрэг бууруулж чадах талаар болон эмчилгээний зардлыг хэр зэрэг хэмнэж болохыг судлах төлөвлөгөөтэй байгаа. Хүнд түлэгдэлттэй өвчтөнүүдийг эмчлэх нь маш их өртөгтэй байдаг. Хэдий эмчилгээний зардал өндөр гардаг ч Монголд эрүүл мэндийн төлбөрийг улсаас нь хариуцдаг. Хэрвээ энэ тавиур нь түлэгдэлтийн эмчилгээний зардлыг хэмнэж чадвал эмчилгээнд ашиглагдах байсан мөнгөөр айлуудад тавиур түгээх болно гэж найдаж байгаа.

Монголын банкнууд болон Дэлхийн Банк, Азийн Хөгжлийн Бангтай хэлэлцээр хийхийн тулд эхлээд шаардлагатай мэдээллийг бэлтгэсэн байх хэрэгтэй байдаг ба бид одоогоор мэдээллүүдийг бэлтгэх шатанд ажиллаж байгаа гэж хэлмээр байна.

Тастанбекова: Баярлалаа.

Ямамото: Өөр асуух асуулттай хүн байгаа бол асууна уу.

Хаффман Жеймс (Ниппон сангийн ажилтан): Намайг Хаффман Жеймс гэдэг. Би Ниппон санд ажилладаг. Нэг зүйл асууж болох уу?

Ямамото: За, асууна уу.

Хаффман: Юуны өмнө зөвхөн мөрөөдөл итгэл найдвар төдийгүй тэдгээрийг хэрхэн бодит амьдралтай холбож аливаа зүйлийг бүтээх талаар гүн сэтгэгдэл төрүүлэх яриа хийсэн профессор танд маш их баярлалаа.

Миний асуулт бол энэхүү төслийн сурталчилгааны

талаар юм. Ийм нийгэмд ашиг тустай санаа шийдлийг олон нийтэд таньж мэдүүлэхийн тулд та бүхний зүгээс ямар ажиллагаа хийж байгаа талаар мэдэхийг хүсэж байна. Энэ тухай ярьж өгнө үү.

Ичикава: Асуулт тавьсанд баярлалаа. Энэ төсөлд зориулж Монгол Улсаас санхүүгийн дэмжлэг туслалцаа үзүүлж буй компаниудын нэг болох Монголын харилцаа холбооны томоохон компани Мобиком корпорац байгаа. Тус компани нь түлэгдэлтээс урьдчилан сэргийлэх талаарх мэдээллийг олон нийтэд түгээх чиглэлээр бидэнтэй хамтран ажиллаж байгаа.

Хаффман: Баярлалаа. Ямар ч ашиг тустай санал, санаачилга, төслүүдийг хэрэгжүүлэхэд олон нийтэд сурталчилж таниулах асуудал үргэлж тулгарч байдаг ба энэ нь өөрөө хэцүү ажил байдаг тул энэхүү асуултыг тавьсан юм. Маш их баярлалаа.

Ямамото: Баярлалаа. Өөр асуулттай хүн байвал асууна уу.

Б.Маргад (Цукубагийн их сургуулийн оюутан): Сайн байна уу, намайг Баярбаатарын Маргад гэдэг. Би Монголоос ирсэн гадаад оюутан. Маш сонирхолтой яриа байлаа.

Магадгүй энэ түлэгдэлтийн хамгийн том шалтгаан нь Улаанбаатар хотод гэр хороолол их байдагтай холбоотой болов уу гэж бодож байна. Иргэдийн тал орчим хувь нь гэрт амьдардаг тул гэр хороолол багасвал иймэрхүү түлэгдэлтийн асуудал бас багасах байх.

Санхүүжилтийн талаар дэвшүүлэх нэг санал байна. Миний сурч байсан Шинэ Монгол гэдэг ахлах сургуулийн захирал одоогоор Монголд иргэдийн төлөөлөгч хийж байгаа. Миний бодлоор энэ төрлийн ажил хийж буй улс төрд ажилладаг ажилтнуудтай хамтран ажиллавал санхүүжилт бүрдүүлэхэд арай хялбар байх болов уу гэж үзэж байна. Үүний талаарх та өөрийн бодлоо хуваалцана уу.

Ичикава: Асуулт тавьсанд баярлалаа. Үнэндээ энэ асуудлаар би Монголын эрүүл мэндийн сайдтай уулзаж байсан боловч саяхан сонгууль болсон байсан.

Маргад: Тийм.

Ичикава: Тэгээд сайд солигдсон. Шинээр сонгогдсон сайд нь Гэмтэл Согог Судлалын Үндэсний Төвийн дарга байсан хүн бөгөөд би өмнө нь түүнтэй уулзаж байсан удаа бий. Тэрээр түлэгдэлтийн аваар ослыг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх талаар ажил хийх маш их хүсэл эрмэлзэлтэй хүн гэж харагдсан. Цаашдаа Монголд очиж байгаад дахин уулзана гэж бодож байгаа.

Үүнээс гадна би өмнө нь Японд айлчилж ирж байсан Монголын улс төрчидтэй уулзаж байсан. Улс төрчидтэй хамтарч ажиллахын тулд тэдний ашиг сонирхлын байдлыг давхар харгалзах шаардлагатай байдаг. Энэ нь тэдэнтэй хамтарч ажиллахад хүндрэлтэй болгодог санагдсан.

Гэхдээ улс төрчдөөс туслалцаа авах нь их чухал гэж

бодож байгаа тул дараагийн удаа шинэ сайдтай заавал уулзана гэж бодож байгаа.

Маргад: Баярлалаа. Дахин нэг санал дэвшүүлэхэд Улаанбаатар хот өвөлдөө нүүрс түлж зуух ашигладаг тул манан татаж агаарын бохирдлын асуудал ихэсдэг. Энэхүү нүүрсний асуудалтай холбогдуулан гэр хорооллын иргэдэд илүү эко зуух түгээх үйл ажиллагаа явагдсан. Иймэрхүү үйл ажиллагааны санхүүжилтээс жишээ авч болох болов уу гэж бодож байна.

Ичикава: Санал тавьсанд баярлалаа. Үүний талаар өмнө нь сонсож байсан.

Маргад: Аа, тийм үү.

Ичикава: Улс төрчдийн санаачилгаар хийгдсэн хэдий ч үр дүнгүй байсан гэж сонссон.

Маргад: Тийм ээ, энэ нь үр дүнгүй ажил байсан.

Ичикава: Өнгөрсөн жилийн 1-р сард Монголд очиход тэнгэр нь маш цэлмэг байсан ба үүнд би их гайхаж байсан. Улсаас чанар муу нүүрс ашиглаж болохгүй гэсэн хатуу арга хэмжээ авсны ачаар сайн чанарын нүүрс хэрэглээд агаарын бохирдол сайжирсан бололтой байсан.

Маргад: Асуултад хариулсан танд маш их баярлалаа.

Ямамото: Асуулт тавьсан та бүхэнд маш их баярлалаа. Одоо цаг бага байгаа ч сая микрофон дамжуулсан Фүжий гуайн асуултыг сонсохыг хүсэж байна.

Фүжий Маюми (Ниппон сангийн ажилтан): Өнөөдөр цаг гаргаж бидэнтэй яриа өрнүүлсэн багш танд маш их баярлалаа. Намайг Фүжий Маюми гэдэг ба би Ниппон санд ажилладаг.

Төсөв олох замдаа маш хэцүү олон саадтай учирсан ч бууж өгөлгүй үргэлжлүүлэн шаргуу судалж олон газарт очсон таны хичээл зүтгэлд маш их сэтгэл хөдөллөө.

Зөвхөн энэ төслийн талаар ч гэлтгүй та өөрийн дотоод хүсэл эрмэлзэл, төслийн санаачлалыг юунаас сэдэл авч бий болгож хийдэг вэ? Энэ талаар товчхон танилцуулж өгөхийг хүсэж байна.

Ичикава: Баярлалаа. Яагаад би иймэрхүү төрлийн төслүүдийг зохион байгуулж ажилладаг вэ гэвэл ... би нийгэмд амьдарч буй хүмүүст бага ч болов тус дэм болохыг хүсдэг болохоор юм. Би дунд болон ахлах сургуульд хичээллэж байх үеэс эхлэн ингэж бодож эхэлсэн. Үнэндээ хүмүүст туслахыг хүсэх нь эргээд өөрийнхөө сэтгэлийг хангалуун байлгахын төлөө байдаг боловч одоог хүртэл миний анхны хүсэл өөрчлөгдөөгүй тэмүүлэлтэй ажилласаар байгаа.

Үнэндээ би Ниппон санд маш их баярлаж явдаг. Ахлах сургуулийн дээд ангид сурч байхдаа би их сургуульд орохын өмнөх хаврын амралтаараа Ниппон сангийн ивээн тэтгэсэн гадаад очиж суралцах аялалд хамрагдаж байсан. Үүнээс өмнө нь би гадаад руу явж үзээгүй байсан ба энэ аялаар Таиландын хойд хэсэгт байрлах Чианг Май ба Чианграй хоёрын хооронд орших Виенпапао хэмээх тосгонд очиж байсан. Тэнд очоод би олон улсын хамтын ажиллагаанд оролцох боломжийг олж авч байсан ба олон улсад өрнүүлж буй хамтын ажиллагаануудад оролцож туслах хүсэл эрмэлзэл маань эндээс эхэлсэн гэж боддог.

Фүжий: Би ч мөн адил одоогоор нэгэн олон улсын хамтын ажиллагааны төслийг хариуцаж байгаа ба энэ удаагийн таны ярианаас үлгэр дууриалал авч цаашдын ажиллагаандаа хэрэгжүүлж гэж бодож байна. Маш их баярлалаа.

Ямамото: Одоо ингээд асуултын цагийг дуусгая гэж бодож байна. Асуулт тавьж төслийн талаарх санал бодлоо хуваалцсан та бүхэнд маш их баярлалаа. Цагийн хязгаарлалтаас болж асуулт тавьж чадаагүй хүрэлцэн ирсэн үзэгчдээсээ хүлцэл өчье. Хэрэв та бүхэнд энэ төслийн талаар асууж тодруулах зүйлс байвал төсөл хариуцагчтай холбоо бариарай. Төсөл хариуцагчаас таны төслийн талаар асуусан асуултуудыг профессор Ичикавад дамжуулах болно.

Өнөөдөр цаг гарган бидэнтэй хамт яриа өрнүүлсэн профессор Ичикава танд маш их баярлалаа. Шинэ төрлийн корона вирусийн тархалттай холбогдуулан энэ удаагийн лекцийг интернетээр зохион байгуулах болсон боловч хүрэлцэн ирсэн үзэгчдийнхээ өмнөөс халуун алга ташилт илгээж дахин чин сэтгэлээсээ талархал илэрхийлэхийг хүсэж байна.

Мөн энэхүү лекц нь Цукубагийн их сургуулийн сурагч, багш нарын бүртгэлийн систем manaba-д цацагдах болно гэдгийг дахин сануулахыг хүсэж байна. Өнөөдрийн лекцийг дахин үзэх хүсэлтэй хүмүүс болон тус лекцэд хүрэлцэн ирж чадаагүй хүмүүст онлайнгаар үзэхийг зөвлөж байна. Онлайн лекцийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг “Ниппон Сангийн Төв Ази - Японы Хүний Нөөц Хөгжүүлэх Төсөл”-ийн веб сайтаас аваарай.

Өнөөдрийн лекц маань ингээд өндөрлөж байна. Бидэнтэй хамт хүрэлцэн ирсэн үзэгч та бүхэнд маш их баярлалаа, баяртай.

**NipCA ТӨСЛИЙН ЗҮГЭЭС ИВЭЭН ТЭТГЭСЭН “ТӨВ ЕВРАЗИ БА
ЯПОНЫ ИРЭЭДҮЙ” ОЛОН НИЙТИЙН ЦУВРАЛ ЛЕКЦ
ЛЕКЦ 11 “МОНГОЛ ХҮҮХДҮҮДИЙГ ТҮЛЭГДЭХ ОСЛООС ХАМГААЛАХЫН
ТӨЛӨӨ АМЬДРАХ ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ”
ЦУКУБАГИЙН ИХ СУРГУУЛИЙН АНАГААХ УХААНЫ ДОКТОР ПРОФЕССОР ИЧИКАВА МАСАО**

2021 оны 4 дүгээр сарын 1

Удирдагч	Үсүяма Тошинобү
Орчуулагч	Э.Номин-Эрдэнэ
Редактор	Кажияма Юүжи, Ямамото Юкико, Таникоши Шооко, Сасаяма Хироши
Хэвлэгч	Үсүяма Тошинобү
Хэвлэлийн газар	Цукубагийн Их Сургууль “Ниппон Сангийн Төв Ази - Японы Хүний Нөөц Хөгжүүлэх Төсөл (NipCA)” 1-1-1 Теннодай, Цукуба хот, Ибараки, Япон Утас: +81-29-853-4251 И-мэйл: info@genis.jinsha.tsukuba.ac.jp Веб Сайт: https://centralasia.jinsha.tsukuba.ac.jp/
Хэвлэл компани	INEXT Co., Ltd.



НИППОН САНГИЙН ТӨВ АЗИ - ЯПОНЫ ХҮНИЙ НӨӨЦ ХӨГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ (NipCA)

Цукубагийн Их Сургууль, 1-1-1 Теннодай, Цукуба хот,
Ибараки 305-8571 Япон
Утас: +81-29-853-4251
И-мэйл: info@genis.jinsha.tsukuba.ac.jp
Веб Сайт: <https://centralasia.jinsha.tsukuba.ac.jp/>



Цуврал лекцийн 11 дэх удаагийн сэдвийн суурь өнгийг НҮБ-аас тогтоосон "Тогтвортой хөгжилд хөтлөх 17 зорилго (SDGs)"-ийн 11 дэх зорилго "Ээлтэй хот, иргэдийн орлоцоог дэмжих" логоны өнгөнөөс сэдэвлэв.